



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

┌ Нийслэлийн өмчийн бүртгэлээс хөрөнгө ┐
хасаж, орон нутгийн өмчийн бүртгэлд
шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 76 дугаар зүйл, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгонд байрлах “Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ-ын баланст бүртгэлтэй, нийт 746.801.600.0 (долоон зуун дөчин зургаан сая найман зуун нэг мянга зургаан зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг нийслэлийн өмчийн бүртгэлээс хасаж, орон нутгийн өмчийн бүртгэлд шилжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний ажлын хүрээнд “Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ-ын баланст бүртгэлтэй хөрөнгийн үнэнд тарьц, суулгац хүлээн авах ажлыг “Хамтран ажиллах, харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн дагуу гэрээ байгуулан зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазарт даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат), Хурлын Ажлын алба (Б.Батбямба)-нд тус тус даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Жагсаалт батлах тухай” 20/21 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтын 2-т заасан “Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ гэсэн хэсгийг хувьчлагдах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалтаас хасаж, Тэргүүлэгчдийн 2019 оны 47 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ж.БАТБАЯСГАЛАН



1110100137